



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/95

Шивээговь сум

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 154 дүгээр “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/168 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдол нэмэгдэж, халдварын голомт тархах эрсдэлт нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Улаанбаатар хот болон халдварын голомтын бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаан (сүүлийн 4 сарын хугацаанд өвчлөөд эдгэрсэн, вакцины 2 дугаар тунд хамрагдаад 14-өөс дээш хоносноос бусад иргэдийн хувьд эрүүл мэнд, аргэрийн гачигдлаар зорчих)-оос бусад тохиолдолд иргэд, тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 06:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарласугай.

2. Хязгаарлалт тогтоосон хугацаанд олон нийтийг хамарсан хурал, цуглаан, үзвэр үйлчилгээ, үзэсгэлэн худалдаа, урлаг соёл, спортын арга хэмжээ, бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ой, байгууллага хамт олны аялал зугаалга, хурим найр, цайллага, хүлээн авалт, уул, овоо тахилгын арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

3. Иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, эргүүл шалгалтыг хийж, чангатгаж ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр), (Онцгой комиссын гишүүд)-д, нүхэн гарц, гармын орох гарах

421217478

хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг 21 дүгээр өртөөний дарга (Г.Ганболор), 22 дугаар зөрлөгийн дарга (П.Оюундулам) нарт, Улаанбаатар хот болон халдвартай бүс нутгаас албан томилолтоор ирж ажиллах иргэдийг хүлээж авахгүй байхыг Албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Мөн хугацаанд тандалт судалгаа, халдварын голомтыг тогтоох ажлыг эрчимжүүлэх, Улаанбаатар хот болон халдварын бүс нутгаас ирж буй иргэдийг журмын дагуу хянаж, ажиглан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Сувданцэцэг), Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр) нарт үүрэг болгосугай.

5. Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбайд бөөгнөрөл үүсгэхгүй, хүн хоорондын зай барин амны хаалтыг тогтмол зүүж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөхийг нийт иргэдэд уриалсугай.

6. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

7. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/88 дугаар захирамжийн 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ